

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН СҮҮЛИЙН 10 ЖИЛИЙН ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
БОЛОН ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИУДЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2024 он

НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ	3
Үнэлгээ хийх үндэслэл:	3
Үнэлгээний аргачлал:	3
Үнэлгээ хийх хүрээ:	3
Үнэлгээний шалгуур үзүүлэлт:	3
Үнэлгээний мэдээлэл цуглуулсан талаар:	4
Үнэлгээ хийсэн бүрэлдэхүүн, хугацаа:	4
ХОЁР.ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН	5
2.1.Удиртгал	5
2.2.Зорилгот хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд	6
2.2.1.ТХМТТХ-д тусгагдсан макро эдийн засгийн 9 үзүүлэлт тус бүрийн хэрэгжилтийн байдал	7
2.2.1.1.ДНБ-ий бодит өсөлтийн талаар	8
2.2.1.2.Хэрэглээний үнийн өсөлт буюу инфляцын талаар	9
2.2.1.3.Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын талаар	10
2.2.1.4.Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээний талаар	11
2.2.1.5.Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн талаар	12
2.2.1.6.Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн талаар	13
2.2.1.7.Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын талаар	14
2.2.1.8.Засгийн газрын өрийн хэмжээний талаар	15
2.2.1.9.Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын талаар	17
2.2.2.Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг дүгнэвэл	18
2.3.Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд	18
2.3.1.Монгол Улсын 2012 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар	18
2.3.2.Монгол Улсын 2013 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар	19
2.3.3.Монгол Улсын 2014 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар	20
2.3.4.Монгол Улсын 2015 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар	21
2.3.5.Монгол Улсын 2016 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар	22
2.3.6.Монгол Улсын 2017 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар	23
2.3.7.Монгол Улсын 2018 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар	25
2.3.8.Монгол Улсын 2019 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар	26
2.3.9.Монгол Улсын 2020 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар	27
2.3.10.Монгол Улсын 2021 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар	28
2.3.11.Монгол Улсын 2022 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар	29
2.3.12.Практикт нийцэж байгаа эсэх шалгуур үзүүлэлтийг дүгнэвэл	32
3.ДҮГНЭЛТ	32
2012-2015 он: Төсвийн төлөвлөлтийг хэт өөдрөгөөр төлөвлөж байсан үе.	32
2016-2019 он: ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдсан үе	33
2019-2022 он: Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үе	33
4.ЗӨВЛӨМЖ	34
Төсвийн төлөвлөлтийн хувьд:	34
Төсөв, эдийн засгийн бодлогын хувьд:	34

Товчилсон үгийн жагсаалт

БНХАУ – Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДНБ – Дотоодын нийт бүтээгдэхүүн
Ковид-19 – Коронавируст халдвар (Ковид-19) цар тахал
МУНТ – Монгол Улсын нэгдсэн төсөв
МУНТТХ – Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль
ТТБТХ – Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
ТХМТТТХ – Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хууль

Зураг

Зураг 1. Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт:
Зураг 2. Оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ /их наяд төгрөг/:
Зураг 3. Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин:
Зураг 4. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/:
Зураг 5. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын ДНБ-д эзлэх хувь:
Зураг 6. Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/
Зураг 7. Нэгдсэн төсвийн нийт зарлагын ДНБ-д эзлэх хувь:
Зураг 8. Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/:
Зураг 9. Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн ДНБ-д эзлэх хувь:
Зураг 10. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/:
Зураг 11. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь:
Зураг 12. Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/:
Зураг 13. Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын ДНБ-д эзлэх хувь:
Зураг 14. Засгийн газрын өрийн хэмжээ өнөөгийн үнэ цэнээр /их наяд төгрөг/:
Зураг 15. Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь:
Зураг 16. Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/:
Зураг 17. Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээний ДНБ-д эзлэх хувь:

Хүснэгт

Хүснэгт 1. ТХМТТТХ, МУНТТХ-ийг анх баталсан болон өөрчлөлт оруулсан огноо:
Хүснэгт 2. ТТБТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтад оруулсан нэмэлт, өөрчлөлт:
Хүснэгт 3. ТТБТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтад оруулсан нэмэлт өөрчлөлт:
Хүснэгт 4. 2012 оны ТХМТТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:
Хүснэгт 5. 2013 оны ТХМТТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:
Хүснэгт 6. 2014 оны ТХМТТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:
Хүснэгт 7. 2015 оны ТХМТТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:
Хүснэгт 8. 2016 оны ТХМТТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:
Хүснэгт 9. 2017 оны ТХМТТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:
Хүснэгт 10. 2018 оны ТХМТТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:
Хүснэгт 11. 2019 оны ТХМТТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:
Хүснэгт 12. 2020 оны ТХМТТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:
Хүснэгт 13. 2021 оны ТХМТТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:
Хүснэгт 14. 2022 оны ТХМТТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:

НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Үнэлгээ хийх үндэслэл: Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын хяналт шалгалтын цаглаврыг Байнгын хороодын болон нам, эвслийн бүлгийн саналыг үндэслэн, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14.3-т заасан Зөвлөлийн хуралдаанаар зөвшилцөн Улсын Их Хурлын даргын захирамжаар батална” гэж заасан. Төсвийн байнгын хорооноос Монгол Улсын Нэгдсэн төсвийн сүүлийн 10 жилийн Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хууль (цаашид “ТХМТТХ” гэх), түүнд өөрчлөлт оруулах тухай хуулиудын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгэх санал ирүүлсний дагуу Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлын цаглаварт тусгасан.

ТХМТТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний зорилго нь хуулийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, хууль анх батлагдан гарч байсан үеийн үзэл баримтлал, хуулийн зорилт, зорилгодоо хүрч байгаа эсэхийг судалж, цаашид хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход хувь нэмэр оруулах явдал юм.

Үнэлгээний аргачлал: Уг хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын (цаашид “аргачлал” гэх) дагуу гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийх хүрээ: ТХМТТХ-ийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийхдээ тус хуульд заасан макро эдийн засгийн 9 үзүүлэлтийн өөрчлөлт болон гарсан үр дүнг харьцуулж дүн шинжилгээ хийсэн болно.

Үнэлгээний шалгуур үзүүлэлт: Аргачлалын үндсэн шалгуур үзүүлэлтүүдээс “зорилгод хүрсэн түвшин”, “практикт нийцэж байгаа байдал” гэсэн хоёр шалгуур үзүүлэлтээр ТХМТТХ-ийн хэрэгжилтийг шалгаж, үр дүнг хэмжих боломжтой гэж үзсэн болно.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Тодорхойлолт
1	Зорилгод хүрсэн түвшин	хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойших хугацаанд хуулийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг тогтоох замаар хууль зорилгодоо хүрсэн эсэхийг тодорхойлно.
2	Практикт нийцэж байгаа байдал	хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой бодит амьдрал дээр гарч буй эерэг болон сөрөг үр дагаврууд, хэрэгжилтийн явцад үүссэн хүндрэл, бэрхшээлийг тодорхойлно.

**Үнэлгээний
мэдээлэл
цуглуулсан
талаар:**

Сонгосон шалгуур үзүүлэлтэд үндэслэн дараах мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

1. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль (цаашид “ТТБтХ” гэх)-ийн хувийн хэрэг;
2. 2012-2023 оны ТХМТТтХ-ийн батлагдсан болон өөрчлөлтийн төсөл, хуулийн хувийн хэргүүд;
3. Монгол Улсын Сангийн яамнаас Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт үнэлгээний газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтэст ирүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсөв (цаашид “МУНТ” гэх)-ийн тайлан;
4. Үндэсний Аудитын Газрын МУНТ-ийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан;
5. Монголбанкнаас гаргадаг эдийн засгийн төлөв байдлын тайлан;
6. Дэлхийн банкнаас сар, улирал бүр гаргадаг Монгол Улсын эдийн засгийн төлөв байдлын тайлан;
7. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргадаг тайлан мэдээлэл зэрэг болно.

**Үнэлгээ
хийсэн
бүрэлдэхүүн,
хугацаа:**

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Б.Буянзаяа, ахлах мэргэжилтэн Г.Чингүнжав нар 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

ХОЁР.ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

2.1.Удиртгал

ТТБтХ батлагдахаас өмнө Монгол Улсад төсөв зохиох, батлах, санхүүжүүлэх, гүйцэтгэлийг хангахтай холбогдсон асуудлыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиар, төсвийн орлого, зарлагын ангилал, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах, төсвийн нягтлан бодох бүртгэлтэй холбогдсон харилцааг Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулиар тус тус зохицуулдаг байсан.

Гэвч төсвийн бодлого, стратеги, төсвийн тогтвортой байдлын удирдлага, түүнийг хангах хэрэгсэл, төсвийн удирдлагын үндсэн зарчим, төсвийн тусгай шаардлагыг олон улсын жишгээр тогтоох, хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын байгууллагын түвшинд төсвийн тогтвортой байдлыг хангах талаарх эрх, үүрэг, хэм хэмжээ, хариуцлага нь бүрэн хэмжээнд хуульчлагдаагүй байжээ.

Улсын төсвийг зохиоход Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлсон төсвийн хүрээний мэдэгдлийг Улсын Их Хурлаас зөвшөөрдөг боловч улсын төсвийн төслийг боловсруулах, төсвийг батлахдаа баримтлахгүй байх, хууль тогтоох байгууллага улсын төсвийн төслийг хэлэлцэх явцдаа Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд тусгагдсан эдийн засгийн өсөлт, төсвийн нийт орлого, түүний дотор татварын орлого, төсвийн нийт зарлага зэрэг суурь үзүүлэлтүүдийг өөрчлөх, санхүү, эдийн засгийн гадаад, дотоод түр зуурын хүчин зүйлийн улмаас бий болсон тогтворгүй орлогыг төсвийн санхүүжилтэд зориулж төсвийг хэт тэлэх шийдвэр гаргадаг¹.

Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгуульд оролцогч улс төрийн нам улс орны эдийн засаг, санхүү, төсвийн бодит боломжоос хэтэрсэн мөнгө хуваарилах, олон нийтэд сонгуулийн хөтөлбөрөөр амлалт өгөх замаар иргэдийн саналыг авах буруу зуршил тогтож болзошгүй бөгөөд энэ нь дараагийн жилүүдэд тодорхой шалтгаанаар төсвийн орлого буурах үед төсвийн санхүүжилтийг өмнөх түвшинд нь уламжлан санхүүжүүлэх боломжгүй болж төсвийн тогтворгүй байдал үүссэн нөхцөлд төсөв тогтворжуулах үндэсний санхүүгийн хуримтлалгүйгээс төсвийн алдагдал нэмэгдэх, нийгэм, эдийн засгийн салбар, улсын хөрөнгө оруулалт зэрэг уламжлалт санхүүжилтийг огцом хасах шаардлага гарч энэ нь иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлөх, улмаар макро эдийн засаг, санхүүгийн тогтворгүй байдал үүсгэж, төсөв санхүүгийн эрсдэл бий болгох магадлалтай байна гэж үзсэн байна.

Дээр дурдсан нөхцөл байдлыг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас Олон Улсын Валютын Сантай 2009 онд байгуулсан Тогтворжуулалтын хөтөлбөрийн дагуу төсвийн удирдлагын хууль эрх зүйн шинэчлэл хийх хүрээнд ТТБтХ-ийн төслийг боловсруулж батлуулсан байдаг.

ТТБтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д ““дунд хугацаа” гэж дараа жилийн болон түүний дараахь дараалсан хоёр жилийг хамарсан төсвийн гурван жилий”, 4.1.10-т ““дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл” гэж тухайн төсвийн жилийн хүлээгдэж байгаа макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал, дунд хугацааны макро эдийн засгийн ба төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилсан төсвийн бодлогын баримт бичгийг” хэлнэ гэж заасан.

Мөн хуулийн 12 дугаар зүйлд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгах үзүүлэлтүүд, тэдгээрийг хэрхэн тооцох талаар тодорхой заасан бөгөөд 7 дугаар зүйлийн

¹ ТТБтХ-ийн төслийн үзэл баримтлал

7.3-т “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ” гэж заасан.

ТТБТХ-д заасан төсвийн тусгай шаардлагад нийцүүлсэн ТХМТТХ-ийг боловсруулж, түүнд нийцүүлэн Монгол Улсын нэгдсэн төсвийн төслийг баталдаг болсноор эрдэс баялгийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээж, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтууд хийх, санхүүгийн хуримтлал бүрдүүлэх нь тус хуулийн үндсэн зорилт юм.

Үнэлгээний баг “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2012 оноос 2022 оны хооронд батлагдсан ТХМТТХ болон өөрчлөлтүүдэд тусгагдсан макро эдийн засгийн 9 үзүүлэлт тус бүрийг бодит гүйцэтгэл, үр дүнтэй харьцуулж, “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд жил бүр ТХМТТХ-д оруулсан өөрчлөлтүүдийн шалтгаан нөхцөлийг тодруулж, хуулийн зохицуулалтын ойлгомжтой байдал, түүнийг хэрэгжүүлэх боломж бололцоо практикт байгаа эсэхийг тодорхойлох замаар үнэлгээ хийсэн болно. ТХМТТХ-д заасан 9 үзүүлэлтийг дурдвал:

1. Дотоодын нийт бүтээгдэхүүн (цаашид “ДНБ” гэх)-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/;
2. Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин;
3. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/, түүний ДНБ-д эзлэх хувь;
4. Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/, түүний ДНБ-д эзлэх хувь;
5. Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/, түүний ДНБ-д эзлэх хувь;
6. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/, түүний ДНБ-д эзлэх хувь;
7. Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/, түүний ДНБ-д эзлэх хувь;
8. Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /их наяд төгрөг/, түүний ДНБ-д эзлэх хувь;
9. Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/, түүний ДНБ-д эзлэх хувь зэрэг болно.

2.2.Зорилгот хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд

ТТБТХ-ийн 12 дугаар зүйлд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, түүнд тусгах үзүүлэлтийн талаар тодорхой заасан бөгөөд түүнд нийцүүлсэн ТХМТТХ-ийн төслийг жил бүр боловсруулж батлуулдаг байна.

ТХМТТХ-ийг батлан мөрдүүлснээр төсвийн бодлого, стратегийг тодорхойлоход төсвийн удирдлагын зарчим ба төсвийн тусгай шаардлагыг тогтоож, дунд, урт хугацааны төсвийн тогтвортой байдлыг хангахад хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын байгууллагын үүрэг хариуцлага өндөрсөж, төсвийн тусгай шаардлагад суурилсан төсвийн удирдлагын эрх зүйн шинэ орчин бүрдэнэ гэж үзсэн.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-т “Улсын Их Хурал Стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэж, батлах” гэж заасны дагуу жил бүрийн 05 дугаар сард дараа жилийн ТХМТТХ-ийг баталдаг ч тухайн жилийн 11 дүгээр сард дараа оны Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль (цаашид “МУНТТХ” гэх) батлагдах үед түүнд нийцүүлэн өөрчлөлт оруулдаг байна.

Төсвийг тогтворжуулах үндсэн зорилго нь ТХМТТХ-д тусгасан хязгаарт нийцүүлэн МУНТХ-ийн төслийг боловсруулах байтал тухайн жилийн төсөвт нийцүүлж ТХМТТХ-д өөрчлөлт оруулдаг жишиг тогтсоныг (Хүснэгт 1)-ээс харж болно.

Хүснэгт 1.ТХМТТХ, МУНТХ-ийг анх баталсан болон өөрчлөлт оруулсан огноо:

Төсвийн жил	Төсвийн хүрээний мэдэгдэл анх баталсан огноо	Төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулсан огноо	Жилийн төсвийг баталсан огноо	Жилийн төсөвт нэмэлт өөрчлөлт оруулсан огноо
2012	2011.07.09	2011.11.30	2011.11.30	
2013	2012.05.22	2012.10.25	2012.11.08	2013.10.25
2014	2013.05.24	2013.11.14 2014.05.23	2013.11.15	2014.05.23 2014.12.18
2015	2014.05.30	2015.01.23 2015.10.30	2014.11.14	2015.01.23 2015.10.30
2016	2015.05.21	2015.11.13 2016.09.09	2015.11.13	2016.09.09
2017	2016.11.10	2017.04.14 2017.10.26	2016.11.10	2017.04.14 2017.10.26
2018	2017.05.31	2017.11.14	2017.11.14	
2019	2018.05.25	2018.11.02	2018.11.02	
2020	2019.05.30	2019.11.13 2020.08.28	2019.11.13	2020.08.28
2021	2020.08.28	2020.11.13 2021.07.07	2020.11.13	2021.07.07
2022	2021.05.13	2021.11.12 2022.01.31 2022.04.29	2021.11.12	2022.01.31 2022.04.29
2023	2022.05.27	2022.11.11 2023.06.15	2022.11.11	2023.06.16
Нийт	12	21	12	13

2012-2023 оны хугацаанд ТХМТТХ-ийг 12 удаа баталсан боловч 2012, 2013, 2018, 2019 онд тус бүр 1 удаа, 2014, 2015, 2016, 2017, 2020, 2021, 2023 онд тус бүр 2 удаа, 2022 онд 3 удаа буюу нийт 21 удаа өөрчлөлт оруулсан байна. Жил бүрийн батлагдсан хуульд эхний өөрчлөлт оруулсан дундаж хугацаа нь 5 сар 10 хоног байна.

ТХМТТХ-ийг ТТБТХ-д заасан тусгай шаардлагуудыг хангасан байдлаар боловсруулдаг ч хагас жил хүрэхгүй хугацаанд өөрчлөлт оруулдаг нь макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг бодитойгоор урьдчилан тооцоолж чадаагүйг илтгэж байна. Үнэлгээ хийх явцад 2023 оны ДНБ болон макро эдийн засгийн бусад үзүүлэлтүүдийн бодит гүйцэтгэл эцсийн байдлаар гараагүй байсан тул 2012-2022 оны мэдээлэлд үндэслэсэн болно.


2.2.1.ТХМТТХ-д тусгагдсан макро эдийн засгийн 9 үзүүлэлт тус бүрийн хэрэгжилтийн байдал

Эдийн засгийн өсөлтийн хурд саарсан шалтгаан нөхцөлийг тодруулахад жил бүрийн төсөв, түүний гүйцэтгэл, төсвийн зарлагын эдийн засагт үзүүлсэн үр өгөөж, хөрөнгө оруулалтуудын үр нөлөө зэргээр маш нарийн тооцоо судалгааг мэргэжлийн байгууллагуудтай хамтарч гүйцэтгэх шаардлагатай тул үнэлгээний баг төсвийн гүйцэтгэлийн бодит үр дүнг, ТХМТТХ-д заасан хэмжээнд байгаа эсэхийг харьцуулж үнэлгээ хийсэн болно.

2.2.1.1. ДНБ-ий бодит өсөлтийн талаар

ТХМТТХ-д тусгагдсан 9 үзүүлэлт тус бүрийн анх батлагдсан, сүүлийн өөрчлөлт, бодит гүйцэтгэл гэсэн гурван дүнг харьцуулж үзэхэд ДНБ-ий бодит өсөлт болон нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 2012-2015 онд хэт өөдрөгөөр төсөөлж төлөвлөсөн нь бодит гүйцэтгэлээс хэт зөрүүтэй байгаа бол, 2016-2019 онд ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-г хамрагдсанаар харьцангуй бодитой төлөвлөж, гүйцэтгэл төлөвлөгөөг давснаар төсвийн алдагдал буурч, 2018, 2019 онд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь хуулийн анхны зорилт болох 2% ба түүнээс бага хэмжээнд хүрсэн байна. Харин 2020-2022 онд Коронавируст халдвар (Ковид-19) цар тахал (цаашид "Ковид-19" гэх)-ын нөлөөгөөр урьдчилан таамаглахад хүндрэлтэй нөхцөл байдлууд үүссэн ч 2022 онд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого төлөвлөгөөг давсан байна.

Зураг 1. Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт:



Жил бүрийн 5 сард баталсан ТХМТТХ-д заасан ДНБ-ий бодит өсөлтийн хувь 2017, 2018, 2022 оноос бусад онуудад зорилтот түвшиндээ хүрээгүй бол ТХМТТХ-д хамгийн сүүлд оруулсан өөрчлөлтөд заасан хэмжээ 2016, 2017, 2018, 2022 оноос бусад онуудад зорилгодоо хүрээгүй байна. (Хавсралт)


2012-2015 онуудад ТХМТТХ-ийг боловсруулахдаа ДНБ-ий бодит өсөлтийг хэт өөдрөгөөр төсөөлж байсан бөгөөд Монгол Улсын нэгдсэн төсвийн төслийг боловсруулах үед эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдөж, дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ унасан, Бүгд Найрамдах Хятад Ард Улс (цаашид "БНХАУ" гэх)-ийн эдийн засгийн өсөлт саарч, дотоод зах зээлийн нүүрсний хэрэглээ буурсан зэрэг нь манай улсын экспортод хүчтэй нөлөөлжээ.

Улмаар ТХМТТХ-ийг батлагдах үеийн экспортын орлого төлөвлөсөн хэмжээнд хүрэхээргүй болсон тул өмнөх төсөөллийн бууруулсан төсвийн төсөл боловсруулж, түүнд нийцүүлэн ТХМТТХ-д өөрчлөлт оруулсан хэдий ч хуулийн анхны хувилбар болон сүүлд оруулсан өөрчлөлтүүдийн хэрэгжилт хангалтгүй (Зураг 1), бодит үр дүнгээс хэт зөрүүтэй гарсан байна.

Харин 2016-2019 онд ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдсанаар 2016, 2019 онуудад төлөвлөгөө болон гүйцэтгэлийн зөрүү багасаж, 2017, 2018 онуудад ДНБ-ий бодит өсөлт төлөвлөгөөг давсан буюу зорилгодоо хүрчээ.

ОУВС-ын зөвлөмжийн дагаж оновчтой төлөвлөж эхэлсэн ч Ковид-19-ийн нөлөөгөөр 2020 онд ДНБ-ий өсөлт огцом унаж эдийн засгийн өсөлт хасах руу орсон бол 2021 эдийн засгийн өсөлт эерэг гарсан ч зорилгодоо хүрээгүй байна. Харин 2022 онд цар тахлын нөлөө багасаж эдийн засгийн өсөлт сэргэж зорилтот түвшинд хүрсэн байна.

Зураг 2. Оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ /их наяд төгрөг/:



Улсын Их Хурлын сонгуулийн жил болох 2016 болон 2020 онд ТХМТТХ-ийг анх батлахдаа ДНБ-ийг хэт өдрөгөөр төсөөлж батлуулсан бөгөөд өөрчлөлтөөр 3 их наяд төгрөгөөр бууруулж баталсан ч гүйцэтгэлээр зорилтот түвшинд хүрээгүй байна. 2021 онд /Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн жил/ ДНБ зорилтот түвшнээс 5 их наяд төгрөгөөр бага гарсан бол 2022 онд зорилтот хэмжээнээс 6 их наяд төгрөгөөр есжээ. (Зураг 2)

2.2.1.2. Хэрэглээний үнийн өсөлт буюу инфляцын талаар

Онолын хувьд инфляц урт хугацаанд нам, тогтвортой хэмжээнд өсөх нь хамгийн зохистой байдаг. Инфляцын түвшин өсөх эсхүл буурах нь эдийн засагт ямар нөлөө үзүүлдгийг энгийнээр товч тайлбарлалаа.

Инфляц **өндөр** байх нь иргэдийн амьжиргааны түвшин буурах, санхүүгийн систем, эдийн засаг тогтворгүй болох эрсдэлийг нэмэгдүүлдэг. Жишээ дурдвал:


- Үнийн өсөлт нь 231 сая хувьд хүрч, 100 триллион дэвсгэрт гүйлгээнд гаргахад хүрч, гипер инфляц иргэдийн худалдан авах чадварт хэрхэн нөлөөлж, эдийн засгийг сүйрүүлж болохыг Зимбабве Улсын 2008 оны үйл явдал;
- Мөнгөн хуримтлалыг богино хугацаанд үнэ цэнгүй цаас болгон хувиргах хурдтай үнийн өсөлт нь банк санхүүгийн системийг хэрхэн тогтворгүй болгодгийг 2016 оны байдлаар 40%-ийн инфляцтай байсан Аргентин, 800%-ийн инфляцтай байсан Венесуэл Улсын жишээ тус тус харуулж байна.

Инфляц **буурах** нь бизнес эрхлэгчдэд сөрөг нөлөө үзүүлдэг. Учир нь ирээдүйн зарах бүтээгдэхүүний үнэ нэмэгдэхгүй байх нь ажилчдынхаа цалинг өсгөх, урамшуулал олгох боломжийг хязгаарладаг. Улмаар ажилчид хөдөлмөрлөх сонирхолгүй болох, бүтээмж, үйлдвэрлэл буурахад нөлөөлдөг.

Инфляц хасах утгатай буюу бүтээгдэхүүний үнэ өсөх бус харин буурч “Дефляци”-тай байх үед компаниуд зардлаа бууруулахын тулд хөрөнгө оруулалтаа танах, ажиллах хүчээ цомхотгох замаар эдийн засаг агшихад нөлөөлдөг болохыг Япон Улсын сүүлийн 30 жилийн түүхээс харж болно.

Үнэ тогтворгүй үед иргэдийн бодит орлого буурах, ядуурал нэмэгдэх, нийгэмд тэгш бус байдал даамжрах гэх мэт олон сөрөг үр дагавар бий болдог.

Зураг 3.Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин:




Манай улсын хувьд инфляцыг тухайн оны зорилтот түвшнээс ± 2 пункт байхыг хэвийн гэж үздэг ч 2012, 2013, 2021 онуудад инфляц ТХМТТХ-д заасан хэмжээнээс хэт өндөр байсан бол, 2015, 2016, онуудад хуульд заасан хэмжээнээс хэт бага түвшинд байсан. Харин 2014, 2017, 2018, 2022 онуудад зорилтот түвшнээс хол зөрүүгүй, зохистой хэмжээнд байжээ. (Зураг 3)

2.2.1.3.Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын талаар


2012-2022 он буюу сүүлийн 11 жилийн хугацаанд 2016, 2017, 2018, 2019, 2021, 2022 онуудад нийт 6 удаа нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ТХМТТХ-д тооцсон хэмжээг давсан байна. 2012-2015 онуудад төлөвлөгөө биелээгүй ч 2016 оноос ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдсанаас хойш Ковид-19-ийн нөлөө өндөр байсан 2020 оныг эс тооцвол бусад жилүүдэд хууль зорилгодоо хүрчээ. (Зураг 4)

Зураг 4.Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/:



Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын ДНБ-д эзлэх хувь 2015-2019, 2017 онуудад ТХМТТХ-д тооцсон хувиас давсан бол бусад жилүүдэд төлөвлөгөөнд хүрээгүй, хуулийн зорилт хангагдаагүй байна. (Зураг 5)


Зураг 5. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын ДНБ-д эзлэх хувь:



2.2.1.4. Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээний талаар


2012-2015 онд ТХМТТХ-д тооцсон хэмжээнд хүрч орлого төвлөрөөгүй нь зарлагын хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс бага гарахад нөлөөлсөн. 2016-2018 онд ОУВС-ийн хөтөлбөрт хамрагдаж, зарим төрлийн шаардлагагүй зардлыг бууруулж, зөв төлөвлөсөн нь хуулийн хэрэгжилт хангагдсах шалтгаан болсон байна. Харин 2019, 2022 онуудад төлөвлөгөөнөөс давсан зарлага гарсан буюу хуулийн хэрэгжилт хангагдаагүй байна. (Зураг 6)

Зураг 6. Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/:



2012, 2021 онуудад нэгдсэн төсвийн нийт зарлагын ДНБ-д эзлэх хувь ТХМТТХ-д заасан хувиас давсан бол бусад жилүүдэд хуульд заасан хэмжээнд, хэрэгжилт хангагдсан байгаа нь жил бүрийн МУНТХ-д нийцүүлэн ТХМТТХ-д өөрчлөлт оруулдагтай холбоотой юм. (Зураг 7)


Зураг 7. Нэгдсэн төсвийн нийт зарлагын ДНБ-д эзлэх хувь:



2.2.1.5. Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн талаар


2012-2014, 2019, 2020, 2022 онд нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ ТХМТТХ-д заасан хэмжээнээс давсан байна. Улсын Их Хурлын сонгуулийн жил болох 2016 онд нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээг 2,556.4 тэрбум төгрөг байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 2,357.4 тэрбум төгрөг гарсан бол 2020 онд ТХМТТХ-д өөрчлөлт оруулж 704.9 тэрбум төгрөг байхаар тооцсон ч 2,242.6 тэрбум төгрөг болж 1,537.7 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. (Зураг 8)

Зураг 8. Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/:



Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн ДНБ-д эзлэх хувь 2014 болон 2019-2022 онд ТХМТТХ-д заасан хэмжээнээс давсан бөгөөд 2020 онд нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн ДНБ-д эзлэх хувь 1.8 хувиас хэтрүүлэхгүй байх зорилт тавьсан ч гүйцэтгэлээр 6.1 хувьтай гарсан байна. (Зураг 9)

Зураг 9. Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн ДНБ-д эзлэх хувь:




2.2.1.6. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн талаар

2012-2022 оны хугацаанд буюу сүүлийн 11 жил нэг ч удаа нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалгүй байхаар тооцоолж ТХМТТХ болон МУНТХ-ийг батлаагүй байна. Харин 2018 онд төлбөрийн тэнцлийг 2,420.1 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар баталсан ч гүйцэтгэлээр 27.9 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.


Жил бүрийн МУНТХ-ийг хэлэлцэж, батлах үеэр ТХМТТХ-ийн өөрчлөлтийг төсөвт нийцүүлэн боловсруулж батлуулдаг тул төлбөрийн тэнцлийн алдагдал батлагдсан хязгаараас давсан тохиолдол 2012 болон 2014 оноос бусад жилүүдэд гараагүй бөгөөд ТХМТТХ-д заасан тус үзүүлэлтийн зорилт хангагдсан гэж үзэж болох ч жил дараалсан төсвийн алдагдал нь ТТБТХ-ийн зорилт болох хуримтлал үүсгэх боломжийг хязгаарлахаас гадна гадаад өрийг нэмэгдүүлэх хүчин зүйлсийн нэг болсон байна.

Түүнчлэн сүүлийн хоёр удаагийн Улсын Их Хурлын сонгуулийн жил төсвийн алдагдлыг хэт өндөр байхаар төлөвлөж баталсан нь ТТБТХ-ийн анхны зорилт алдагдахад нөлөөлсөн. (Зураг 10)

Зураг 10. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/



Зураг 11. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь:



ТТБТХ-ийг анх батлахдаа нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг тухайн төсвийн жилийн ДНБ-ий 2 хувиас хэтрүүлэхгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх хязгаарлалтыг тогтоож, түүнд нийцүүлэн жил бүрийн ТХМТТХ, МУНТХ-ийг боловсруулж батлуулахаар заасан ч ТТБТХ-д нэмэлт өөрчлөлт оруулж, 2 хувиас хэтрүүлэхгүй байх хязгаарыг 2025 оноос хэрэгжүүлж эхлэхээр болсон. (Хүснэгт 2)

Хүснэгт 2.ТТБТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтад оруулсан нэмэлт, өөрчлөлт:


6 дугаар зүйлийн “6.1.2.нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх;”	Тусгай шаардлагад нэмэлт, өөрчлөлт өөр оруулсан хувь хэмжээ				
	2015.01.20	2016.09.09	2017.04.14	2021.07.07	
Хэрэгжих эхлэх огноо	2015	5%	5%		
	2016	4%	18.5%		
	2017	3%	9.9%	10.4%	10.4%
	2018	2%	7.5%	9.5%	9.5%
	2019		5.5%	6.9%	6.9%
	2020		0%	5.1%	12.5%
	2021			3.6%	8.8%
	2022			2.8%	5.1%
	2023			2.0%	3.6%
	2024				2.8%
2025				2.0%	

ТТБТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтад өөрчлөлт оруулах замаар хэрэгжих хугацааг удаа дараа хойшлуулж, түүнд нийцүүлсэн төсвийн төслийг боловсруулдаг нь ТХМТТХ-д заасан тусгай шаардлага хангагдаж байгаа мэт боловч, нөгөө талаар төсвийн алдагдлыг бууруулах, цаашлаад төсвийг ашигтай баталж, хуримтлал үүсгэх ТТБТХ-ийн анхны зорилт батлагдсанаас хойш өнөөдрийг хүртэл хэрэгжээгүй байна.

2.2.1.7.Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын талаар


2012-2022 онд жил бүрийн ТХМТТХ-д заасан нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээг заасан үзүүлэлтийн хэрэгжилт хангагдсан байна (Зураг 12). 2019-2022 онд хөрөнгийн зардлын хэмжээг нэмэгдүүлж 3,251.8-4,296.3 тэрбум төгрөг болгож төлөвлөжээ.

Зураг 12.Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/:



2016 болон 2021 оноос бусад жилүүдэд нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын ДНБ-д эзлэх хувь ТХМТТХ-д заасан хэмжээнээс бага гарчээ. (Зураг 13)

Зураг 13.Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын ДНБ-д эзлэх хувь:




2.2.1.8. Засгийн газрын өрийн хэмжээний талаар

2014-2018 онд Засгийн газрын өрийн хэмжээг нэмэгдүүлэхээр тооцоолж ТХМТТХ-ийг баталсан. Харин 2019 онд 2018 оноос 4.7 их наяд төгрөгөөр буурч 19.6 их наяд төгрөг байхаар тооцсон бол 2020 онд 2019 оноос 4.5 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж 24.1 их наяд төгрөг байхаар тооцсон бөгөөд 2019-2022 онд ТХМТТХ-д Засгийн газрын өрийн хэмжээг бууруулах талаар төлөвлөөгүй нь өсөлтийн хэмжээнээс харагдлаа. (Зураг 14)

Өнөөгийн үнэ цэнээр тооцсон Засгийн газрын өрийн нийт хэмжээ Улсын Их Хурлын сонгуулийн жил болох 2016 онд 2015 оноос 6.9 их наяд төгрөгөөр нэмэгдэж 18.9 их наяд төгрөг, 2020 онд 2019 оноос 2.5 их наяд төгрөгөөр нэмэгдэж 23.0 их наяд төгрөг, 2022 онд 2021 оноос 5.1 их наяд төгрөгөөр нэмэгдэж 26.9 их наяд төгрөг болсон. (Зураг 14).

Зураг 14.Засгийн газрын өрийн хэмжээ өнөөгийн үнэ цэнээр /их наяд төгрөг/:




ТТБТХ-д нэмэлт өөрчлөлт оруулах замаар (Хүснэгт 3) Засгийн газрын өрийн таазыг нэмэгдүүлж баталсан. Тус нэмэлт өөрчлөлтөд заасан хэмжээний дагуу хуулийн хэрэгжилт хангагдаж байгаа мэт боловч хуулийн анхны үзэл баримтлал, зорилт болох Засгийн газрын өрийн хэмжээг ДНБ-ий 40 хувиас хэтрүүлэхгүй байх зарчим алдагдсан. (Зураг 15)

Хүснэгт 3. ТТБТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтад оруулсан нэмэлт өөрчлөлт:

6.1.4.Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 40 (2016 оноос 60) хувиас хэтрэхгүй байх.		Тусгай шаардлагад нэмэлт, өөрчлөлт оруулсан огноо		
		2015.01.20	2016.09.09	2021.07.07
Хэрэгжих эхлэх огноо	2015	58.3%	58.3%	
	2016	55%	88.0%	
	2017	50%	85.0%	
	2018	40%	80.0%	
	2019		75.0%	
	2020		70.0%	
	2021		60.0%	70%
	2022			70%
	2023			65%
	2024			60%

2022 онд Засгийн газрын өрийн хэмжээ 26.9 их наяд төгрөг болж нэмэгдсэн ч ДНБ эзлэх хувь 50.8 хувь болж буурсан. Энэ нь 2022 онд ДНБ 52.9 их наяд төгрөг болж өмнөх оноос 16 их наяд төгрөгөөр өссөнтэй холбоотой. (Зураг 2)


Зураг 15. Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь:



Цаашид төсвийг алдагдалгүй баталж, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтууд хийх, санхүүгийн хуримтлал бүрдүүлэх, засгийн газрын өрийн дарамтыг бууруулж ДНБ-д эзлэх хувийг хуульд заасан хэмжээнд хүргэх шаардлагатай.


2.2.1.9. Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын талаар

Зураг 16. Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/:



2021 онд Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээг 2,994.7 тэрбум төгрөг байхаар тооцож гүйцэтгэлээр 2,851.1 тэрбум төгрөг зарцуулсан бол 2022 онд энэ хэмжээ огцом буурч 490.4 тэрбум төгрөг төсөвлөж 511.6 тэрбум төгрөг зарцуулсан.

Зураг 17. Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээний ДНБ-д эзлэх хувь:



Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэхэд чиглэсэн тодорхой шийдлийг дотоод нөөц бололцоогоо дайчлан яаралтай боловсруулж, үе шаттай авч хэрэгжүүлэн ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосны дагуу Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтыг үндэслэж 2022 оны улсын төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсөвт тодотгол хийх замаар Нийгмийн даатгалын сангийн 2021 оны давсан орлогын эх үүсвэрийг ашиглан ахмадуудын тэтгэврийг үе шаттай нэмэгдүүлэхээр тооцсон нь 2022 онд тус үзүүлэлтийн хэмжээ 511.6 тэрбум төгрөг болж өмнөх оноос 2.3 их наяд төгрөгөөр буурах үндэслэл болжээ.

2.2.2.Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг дүгнэвэл

ТХМТТХ-д заасан макро эдийн засгийн 9 үзүүлэлт тус бүр сүүлийн 10 жил хуульд заасан зорилтот түвшинд хүрсэн эсэхийг жил бүрийн төсвийн гүйцэтгэлтэй харьцуулсан байдлаар үнэлгээ хийхэд 2018 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтөд заасан 9 үзүүлэлт бүгд хуульд заасан хэмжээнд үр дүнтэй гарсан бол, бусад жилүүдэд зарим үзүүлэлтүүд зорилтод түвшинд хүрээгүй, хуулийн хэрэгжилт үр дүнгүй байна. (Хавсралт)

2.3.Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Энэ хэсэгт 2012-2022 оны хооронд хуулийн анх батлагдсан үзүүлэлт, мөн тухайн онд оруулсан өөрчлөлтөд заасан тоон үзүүлэлтийг бодит гүйцэтгэлтэй харьцуулж он тус бүрээр ТХМТТХ-д өөрчлөлт оруулах болсон шалтгааныг тухайн хуулийн төслийн үзэл баримтлалд хэрхэн тусгасан талаар тодруулах бөгөөд тус шалгуур үзүүлэлтийн дүгнэлт хэсэгт хууль хэрэгжихтэй холбоотой бодит амьдрал дээр гарч буй эерэг болон сөрөг үр дагаврууд, хэрэгжилтийн явцад гарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлно.

ТТБТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ” гэж заасныг хууль эрх зүйн үндэслэл болгож ТХМТТХ-д жил бүр 1-3 удаа өөрчлөлт оруулсан.

Жил бүрийн ТХМТТХ-ийг батлах үеийн манай улсын эдийн засгийн төлөв БНХАУ-ын эдийн засгийн нөхцөл байдал, уул уурхайн гаралтай түүхий эдийн эрэлтээс шалтгаалан хагас жилийн дараа буюу төсөв батлах үед өөрчлөгдсөн байдаг. Энэ нь нэг талаар манай хуулийн төсөл боловсруулагчид эдийн засгийн төлөв байдлыг хагас жилийн өмнөөс харж тооцоолж чадахгүй байгааг, нөгөө талаар манай улсын эдийн засаг уул уурхайн түүхий эдийн экспортоос хэт хамааралтай байгааг харуулж байна.

2.3.1.Монгол Улсын 2012 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар

Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлахтай холбогдуулан Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуулийн нэрийг “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2012 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2013-2014 оны төсвийн төсөөллийн тухай” гэж өөрчилсөн бөгөөд 2011 оны 07 дугаар сарын 09-ний өдөр баталсан 2012 оны ТХМТТХ нь ТТБТХ-ийг баримтлан боловсруулсан анхны баримт бичиг юм.

Хүснэгт 4.2012 оны ТХМТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2011.07.09 /баталсан/	2011.11.30 /өөрчлөлт/	Гүйцэтгэл 2012
1	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/	16.6	19.7	12.3
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	9.0	9.0	14.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	4,176.1	5,825.7	4,881.2
	ДНБ-д эзлэх хувь	29.8	36.1	35.0
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	5,113.5	6,309.5	6,017.8
	ДНБ-д эзлэх хувь	36.5	39.1	43.2
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	25.2	27.9	1,020.7
	ДНБ-д эзлэх хувь	7.3	8.5	7.3
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-937.4	-483.8	-1,136.6
	ДНБ-д эзлэх хувь	-6.7	-3.0	-8.2

7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	1,098.3	2,001.0	1,525.4
	ДНБ-д эзлэх хувь	7.8	12.4	10.9
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /их наяд/	7.3	5.7	
	ДНБ-д эзлэх хувь	51.9	35.3	
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	218.8	222.5	
	ДНБ-д эзлэх хувь	1.8	1.4	

2011 оны 11 дүгээр сард ТХМТТХ-д өөрчлөлт оруулахдаа 2012 оны эдийн засгийн нөхцөл байдал, уул уурхайн бүтээгдэхүүний дэлхий зах дээрх үнэ, экспортын хэмжээ зэргийг өөдрөгөөр төсөөлөхөд 2011 оны эдийн засаг, гадаадын хөрөнгө оруулалтын өсөлт, уул уурхайн түүхий эдийн таатай нөхцөл зэрэг нь нөлөөлсөн байна. Гэвч 2012 онд БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарсантай холбоотойгоор Монгол улсын нүүрсний экспортын хэмжээ болон уул уурхайн түүхий эдийн үнэ буурсан нь эдийн засгийн өсөлтийг сааруулсан ч хөдөө аж ахуйн салбар сэргэж, барилга, тээврийн салбарууд тогтвортой өссөний үр дүнд эрдсийн бус салбарын гүйцэтгэл өндөр гарч эдийн засгийн өсөлт хоёр оронтой тоог хадгалж 12.3 хувьтай гарчээ.

Хэдийгээр ТХМТТХ-ийг бодитойгоор тооцоолж түүнд нийцүүлэн МУНТ-ийн төслийг боловсруулж батлуулах ёстой ч практик дээр макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг бодитойгоор тооцоолж чадаагүй, төсвийн зарлагыг өндөр төлөвлөхийн тулд орлогыг өөдрөгөөр төсөөлсөн. Улмаар төсвийн төсөл боловсруулахдаа түүнд нийцүүлэн ТХМТТХ-д өөрчлөлт оруулдаг байдал нь тус хууль практикт нийцэхгүй байгааг харуулж байна.

2.3.2. Монгол Улсын 2013 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар

Баяжуулсан болон коксжих нүүрсний экспортын үнийн огцом уналт, Хятадын нүүрсний эрэлт буурсан зэрэг нь 2013 оны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах үед тооцсон эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ, хэмжээ болон төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, ялангуяа ДНБ-ий хэмжээ буурахад нөлөөлсөн нь анх баталсан өөдрөг төсөөллийг бууруулах шалтгаан болжээ.

Хүснэгт 5.2013 оны ТХМТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2012.05.22 /баталсан/	2012.10.25 /өөрчлөлт/	Гүйцэтгэл 2013
1	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/	19.0	17.6	11.6
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	9.8	8.0	12.5
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	7,473.0	7,088.3	5,940.1
	ДНБ-д эзлэх хувь	39.2	40.2	33.8
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	7,860.4	7,449.2	6,164.7
	ДНБ-д эзлэх хувь	41.2	42.2	35.1
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /хувь/	21.5	18.0	146.9
	ДНБ-д эзлэх хувь	7.3	6.4	0.8
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-387.4	-360.9	-224.6
	ДНБ-д эзлэх хувь	-2.0	-2.0	-1.3

7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	3,297.9	2,491.6	1,490.7
	ДНБ-д эзлэх хувь	17.3	14.1	8.5
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /их наяд төгрөг/	6.4	8.1	-
	ДНБ-д эзлэх хувь	33.6	46.0	-
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	309.3	262.6	37.9
	ДНБ-д эзлэх хувь	1.6	1.5	0.2

2013 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх жилийн түвшнээс 2 дахин буурч уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээл суларснаас улсын эдийн засгийн өсөлт саарч эхэлсэн. Монгол улсын Засгийн газар болон мөнгөний бодлогын эрх баригчид эдийн засгийн тэлэх бодлогыг хэрэгжүүлсэн. Төв банкнаас зээлийг нэмэгдүүлэх зорилгоор ДНБ-ий 20 хувьтай тэнцэх хэмжээний бэлэн мөнгийг нийлүүлж, Монгол улсын Хөгжлийн банкнаас хийсэн төсвийн гадуурх ихээхэн хэмжээний санхүүжилт зэрэг нь инфляцын түвшин өсөхөд нөлөөлсөн ч эдийн засгийн өсөлтийг хоёр оронтой тоонд барьж чаджээ.

2.3.3. Монгол Улсын 2014 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар

2013 оны 11 дүгээр сарын 24-ний анхны өөрчлөлтийн тухайд

Дэлхийн эдийн засагт гарч буй өөрчлөлтийн улмаас манай улсын уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ 2014 оны ТХМТТХ боловсруулж байсан үеэс буурсан, Оюутолгойн ордын үйлдвэрлэлийн хэмжээ төлөвлөснөөс буурч, нүүрсний олборлолт багассан нь ДНБ-д нөлөөлсөн. Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулж буй үед ТТБТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.3²-т заасан үндэслэлээр ТХМТТХ-д өөрчлөлт оруулах шаардлага үүссэн гэжээ.

2014 оны 05 дугаар сарын 23-ны хоёр дахь өөрчлөлтийн тухайд

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3-т “урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлнэ” гэж, 34 дүгээр зүйлийн 34.1.2-т “урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэх”, 34.1.4-т “Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх” тохиолдолд тодотголын төслийг боловсруулна гэж, “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын 2014 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 30 дугаар тогтоолд Монгол Улсын 2014 оны төсвийн тодотголын төслийг нэг тогтоолын хүрээнд боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж тус тус заасан нь Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах хууль эрх зүйн шаардлагаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах шалтгаан болсон.

Өөрчлөлтийг батлахдаа төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ, нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлж, ДНБ-ий өсөлтийг бууруулж тооцсон бөгөөд

² ТТБТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ” гэж заасан.

гүйцэтгэлээр эдгээр үзүүлэлтүүд хангалтгүй гарахад 2013 онд 17.4 хувиар өсөж байсан эрдсийн бус салбарын өсөлт 2014 онд 2 хувь болж огцом буурсан нь нөлөөлжээ.

Хүснэгт 6. 2014 оны ТХМТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2013.05.24 /баталсан/	2013.11.24 /өөрчлөлт/	2014.05.23 /өөрчлөлт/	Гүйцэтгэл 2014
1	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/	14.7	14.8	11.2	7.9
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	6.0	8.0	9.0	11.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	7,270.0	6,883.9	6,903.8	6,276.6
	ДНБ-д эзлэх хувь	35.0	33.6	33.7	28.6
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	7,686.3	7,293.9	7,313.8	7,144.6
	ДНБ-д эзлэх хувь	37.0	35.6	35.7	32.6
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	3.2	0.0	684.0	979.9
	ДНБ-д эзлэх хувь	1.2	3.2	3.3	4.5
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-416.3	-410.0	-410.0	-868.0
	ДНБ-д эзлэх хувь	-2.0	-2.0	-2.0	-4.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	2,299.5	2,006.2	2,006.4	1,771.1
	ДНБ-д эзлэх хувь	11.1	9.8	9.8	8.1
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /их наяд төгрөг/	8.3	8.2	8.2	10.8
	ДНБ-д эзлэх хувь	40.0	40.0	40.0	49.3
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	277.7	266.8	266.8	33.9
	ДНБ-д эзлэх хувь	1.3	1.3	1.3	0.2

2.3.4. Монгол Улсын 2015 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар

2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн эхний өөрчлөлтийн тухайд

Дэлхийн зах зээл дээр үүссэн өөрчлөлтийн улмаас экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ буурах хандлагатай байгаа төдийгүй Оюутолгойн ордын үйлдвэрлэлийн хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс буурч, нүүрсний олборлолт багассанаар 2014 онд ДНБ-ий хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй нь 2015 оны ДНБ-д мөн нөлөөлөхөөр болсон. Түүнчлэн, манай улсын уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох зэсийн баяжмалын олборлолт, баяжуулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт гарч, бүтээгдэхүүний агуулга, гарц багассан ба дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ буурснаас жоншны борлуулалт багасахаар байгаа нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан төсвийн орлого, нийт зарлага болон нийт тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг өөрчлөх үндэслэл болсон.

Тус өөрчлөлтөөр ДНБ-ий өсөлт, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг бууруулж, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг нэмэгдүүлж баталсан бөгөөд 9 сарын дараа дахин өөрчлөлт оруулжээ.

2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хоёр дахь өөрчлөлтийн тухайд

Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал, дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнийн уналтаас шалтгаалан Монгол Улсын 2015 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр ДНБ-ий хэмжээ оны эхэнд төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй хандлагатай байгаа нь төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах үед тооцсон эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ, хэмжээ, төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нийцүүлэн өөрчлөх шалтгаан болжээ.

Энэ хүрээнд Улсын нэгдсэн төсвийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах болсонтой холбоотойгоор төсвийн урьдчилсан гүйцэтгэлд үндэслэн ТХМТТХ-д өөрчлөлт оруулсан нь бодит гүйцэтгэлээс зөрүү багатай гарах үндэслэл болсон.

Хүснэгт 7.2015 оны ТХМТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2014.05.30 /баталсан/	2015.01.23 /өөрчлөлт/	2015.10.30 /өөрчлөлт/	Гүйцэтгэл 2015
1	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/	10.2	7.1	3.1	2.4
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	7.0	7.0	6.5	1.9
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	7,201.1	6,632.6	6,074.1	5,981.1
	ДНБ-д эзлэх хувь	29.4	27.6	25.8	25.8
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	7,690.9	7,837.4	7,253.3	7,138.0
	ДНБ-д эзлэх хувь	31.4	32.7	30.8	30.8
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	378.5	484.7	108.7	-6.6
	ДНБ-д эзлэх хувь	1.5	2.0	0.5	-0.03
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-489.8	-1,204.8	-1,179.2	-1,156.9
	ДНБ-д эзлэх хувь	-2.0	-5.0	-5.0	-5.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	1,967.3	2,015.0	1,530.7	1,396.7
	ДНБ-д эзлэх хувь	8.0	8.4	6.5	6.0
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /их наяд төгрөг/	9.8	13.99	13.7	12.0
	ДНБ-д эзлэх хувь	40.0	58.3	58.3	51.8
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	272.8	285.6	284.9	34.2
	ДНБ-д эзлэх хувь	1.1	1.2	1.2	0.1

2.3.5. Монгол Улсын 2016 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар

2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн өөрчлөлтийн тухайд

2016 онд уул уурхайн томоохон төслүүдийн хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлснээр төсвийн орлого нэмэгдэх, түүнчлэн УИХ-ын 2015 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг баталсан ба хууль хэрэгжиж эхэлснээр далд эдийн засаг буурах, татвар төлөгчийн илрээгүй байсан орлого, хөрөнгө ил болж, тэдгээрийг хууль ёсны бүртгэлд оруулж, татварын бааз суурь өргөжсөнөөр татварын орлого нэмэгдэх боломж бүрдэнэ

гэж үзсэн байна. Улмаар ТХМТТХ-д тусгасан эдийн засгийн үзүүлэлтүүдийг өөрчилж төсвийн орлого, зарлагын нэмэгдүүлж баталжээ.

2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн өөрчлөлтийн тухайд

Гадаад эдийн засгийн нөхцөл байдал, дотоод эдийн засгийн хүндрэл нь эдийн засгийн өсөлтийг сулруулж, төсвийн орлогыг их хэмжээгээр бууруулах болсон байна. Үүний улмаас Монгол Улсын 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах үед тооцсон эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ, хэмжээ, төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, ялангуяа ДНБ-ий хэмжээ буурахаар байгаагаас үүдэн төсөвт тодотгол хийх болсонтой холбогдуулан ТХМТТХ-ийн үндсэн үзүүлэлтүүдийн хэмжээг өөрчлөх зайлшгүй шаардлага бий болсон гэж үзэж, ДНБ-ий өсөлтийн 2.7 пунктээр, төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 1.7 их наяд төгрөгөөр бууруулсан ч нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг 1.7 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна. Тус өөрчлөлт нь 2016 оны III улиралд хийгдсэн тул бодит гүйцэтгэлээс хол зөрүүтэй гараагүй байна.

Хүснэгт 8.2016 оны ТХМТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2015.05.21 /баталсан/	2015.11.13 /өөрчлөлт/	2016.09.09 /өөрчлөлт/	Гүйцэтгэл 2016
1	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/	5.0	4.1	1.3	1.5
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	6.0	7.0	7.0	1.1
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	6,642.0	7,013.9	5,348.2	5,835.0
	ДНБ-д эзлэх хувь	24.6	25.4	22.1	24.4
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	7,722.8	7,954.4	9,694.4	9,496.3
	ДНБ-д эзлэх хувь	28.6	28.8	40.1	39.8
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	2,556.4	701.1	2,556.4	2,357.4
	ДНБ-д эзлэх хувь	-0.4	2.5	10.6	9.9
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,080.8	-940.5	-4,346.2	-3,661.0
	ДНБ-д эзлэх хувь	-4.0	-3.4	-18.0	-15.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	1,453.9	1,930.5	2,350.0	2,360.2
	ДНБ-д эзлэх хувь	5.4	7.0	9.7	9.9
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /их наяд төгрөг/	14.9	15.2	21.3	18.9
	ДНБ-д эзлэх хувь	55.0	55.0	88.0	79.2
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	303.5	295.2	294.9	33.9
	ДНБ-д эзлэх хувь	1.1	1.1	1.2	0.1

2.3.6. Монгол Улсын 2017 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар

2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн өөрчлөлтийн тухайд

2012-2016 оны хооронд гадаад, дотоод эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал, уул уурхайн салбараас хамаарсан төсвийн зарлагын хэт өсөлт, төсвийн сахилга бат, нэгдмэл байдал хангалтгүйгээс төсвийн алдагдал ихээхэн хэмжээгээр нэмэгдэж,

улмаар өндөр хүүтэй үнэт цаас гаргах замаар төсвийн алдагдлыг санхүүжүүлж байсан зэрэг нь Засгийн газрын өрийн хэмжээг огцом нэмэгдүүлж, зээлийн хүүгийн төлбөрийн дарамт өссөнөөр төсвийн тэнцвэргүй байдлыг бий болгосон.

Улмаар Монгол Улсын Засгийн газрын зүгээс ОУВС-тай хамтран 3 жилийн хугацаатай “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, нэн тэргүүнд төсвийн нэгдмэл байдлыг бодитойгоор хангах, сахилга батыг чангатгах, төсвийн орлогын тогтвортой эх үүсвэрийг бий болгох, төсвийн зарлагын үр ашгийг сайжруулах замаар дунд болон урт хугацааны төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулахаар зорьсон.

Хөтөлбөрийн хүрээнд төсвийн бодлогын хэд хэдэн шинэчлэлийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаатай уялдуулан дунд хугацааны макро эдийн засгийн тооцоолол, төсвийн орлого, зарлагын төсөөлөл зэрэг үндсэн үзүүлэлтүүд өөрчлөгдөхөөр болсон нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан төсвийн үндсэн үзүүлэлтийн хэмжээг өөрчлөх шаардлага үүссэн байна.

2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 2 дахь өөрчлөлтийн тухайд

Эдийн засгийн өсөлт эхний хагас жилийн байдлаар 5.3 хувьд хүрч сэргэсэн. Нүүрсний экспорт эрчимтэй нэмэгдэж, голлох ашигт малтмалын үнэ харьцангуй өндөр түвшинд хүрсэн нь уул уурхай, түүнийг дагасан эдийн засгийн бусад салбарт өсөлт бий болж, аж ахуйн нэгжүүдийн борлуулалт нэмэгдсэн зэрэг нь 2017 онд төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс давж биелэхэд нөлөөлжээ.

ОУВС болон Монгол Улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн эхний шатны үнэлгээг 2017 оны 07 дугаар сарын 19-ний өдрөөс 08 дугаар сарын 02-ны өдрийн хооронд ажлын хэсгийн түвшинд хийж зорилтод үзүүлэлтүүдийг шинэчлэн тохирсон. Хөтөлбөрийн хүрээнд тохирсны дагуу төсвийн давсан орлогын тодорхой хэсгийг дараах үндэслэл, шаардлагын дагуу зарцуулах болсон байна. Тухайлбал,

1/ хүүхдийн мөнгө хөтөлбөрийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд нэмж шаардагдах зардлыг төсөвт тусгах;

2/ өсөн нэмэгдэж байгаа боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний эрэлт, хэрэгцээнд нийцүүлж шаардагдах зардлыг тооцож төсөвт тусгах;

3/ 2018 он болон түүний дараагийн жилүүдэд төсөвт дарамт үзүүлэхгүй, нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий нэг удаагийн шинжтэй зардлыг тусган хэрэгжүүлэх;

4/ өмнөх жилүүдэд гэрээ нь хийгдсэн “Барих-Шилжүүлэх” концессын төслийн эргэн төлөлт, хөнгөлөлттэй зээлийн Монголын талын хариуцах санхүүжилт, шүүхийн шийдвэртэй болон бусад өр төлбөрүүдийг барагдуулах зэрэг зайлшгүй шаардлага үүсэж төсөвт тодотгол хийхдээ холбогдуулан ТХМТТХ-д өөрчлөлт оруулсан.

Хүснэгт 9.2017 оны ТХМТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2016.11.10 /баталсан/	2017.04.14 /өөрчлөлт/	2017.10.26 /өөрчлөлт/	Гүйцэтгэл 2017
1	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/	3.0	-0.2	3.3	5.6
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	6.5	6.1	7.7	6.4
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/ ДНБ-д эзлэх хувь	6,160.2 23.3	6,035.7 23.2	6,537.1 23.8	7,274.9 26.8

4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	8,568.9	8,750.2	9,154.5	9,017.3
	ДНБ-д эзлэх хувь	32.3	33.6	33.4	33.2
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	-1,125.5	-944.2	-340.8	-478.0
	ДНБ-д эзлэх хувь	-4.2	-3.6	-1.2	-1.8
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-2,408.7	-2,714.4	-2,617.4	-1,742.5
	ДНБ-д эзлэх хувь	-9.1	-10.4	-9.5	-6.4
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	1,483.9	1,579.8	1,813.5	1,658.1
	ДНБ-д эзлэх хувь	5.6	6.1	6.6	6.1
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /их наяд төгрөг/	22.4	22.1	23.3	20.2
	ДНБ-д эзлэх хувь	84.4	85.0	85.0	74.4
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	467.3	470.0	583.1	311.7
	ДНБ-д эзлэх хувь	1.8	1.8	2.1	1.1

2.3.7. Монгол Улсын 2018 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар

2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн өөрчлөлтийн тухайд

Эдийн засгийн өсөлт 2017 оны эхний хагас жилийн байдлаар 5.3 хувьд хүрч, нүүрсний экспорт эрчимтэй нэмэгдэж, голлох ашигт малтмалуудын үнэ харьцангуй өндөр түвшинд байгаа болон уул уурхай, түүнийг дагасан эдийн засгийн бусад салбарын өсөлтөөс үүдэн эдийн засгийн орчин харьцангуй идэвхжиж, аж ахуйн нэгжүүдийн борлуулалт, ашигт ажиллагаа нэмэгдсэнтэй холбоотой тайлант онд төвлөрүүлэхээр тооцсон төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс давсан.

Давсан орлогын тодорхой хэсгийг нэг удаагийн шинж чанартай, ирэх жилүүдэд төсөвт ачаалал үүсгэхгүй байх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, болзошгүй өр төлбөрийг барагдуулах, цаг үеийн нөхцөл байдал, үүссэн бодит хэрэгцээ, шаардлагыг харгалзан зайлшгүй нэмэгдүүлэх чиглэлээр төсвийн зарлагад зарим өөрчлөлтүүдийг тусган төсөвт тодотгол хийх талаар Олон улсын валютын сангийн хөтөлбөрийн эхний шатны үнэлгээний явцад тохирсон.

Хөтөлбөрийн эхний үнэлгээтэй холбоотойгоор дунд хугацааны макро эдийн засгийн тооцоолол, төсвийн орлого, зарлагын төсөөлөл зэрэг үндсэн үзүүлэлтүүд өөрчлөгдөхөөр болсон нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн хэмжээг өөрчлөх зайлшгүй шаардлагыг бий болсон.

Тус өөрчлөлтөөр ДНБ-ий өсөлтийг 4.2 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 7,231.4 тэрбум төгрөг байхаар, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн зарлагын дээд хэмжээг 9,651.5 тэрбум төгрөг байхаар тооцож баталсан. Харин бодит гүйцэтгэлээр ДНБ-ий өсөлт 7.7 хувьд, төсвийн орлого 9,345.1 тэрбум төгрөг болж 2,113.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, төсвийн зарлага 334.3 тэрбум төгрөгөөр буурснаар 2012-2022 оны хугацаанд анх удаа 2018 онд төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарсан байна. (Хүснэгт 10)

Хүснэгт 10.2018 оны ТХМТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2017.05.31 /баталсан/	2017.11.14 /өөрчлөлт/	Гүйцэтгэл 2018
1	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/	1.8	4.2	7.7
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	6.1	8.6	8.1
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	6,808.4	7,231.4	9,345.1
	ДНБ-д эзлэх хувь	24.6	23.8	29.1
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	9,451.0	9,651.5	9,317.2
	ДНБ-д эзлэх хувь	34.1	31.8	29.0
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	700.8	497.0	205.6
	ДНБ-д эзлэх хувь	2.5	1.6	0.6
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-2,642.6	-2,420.1	28
	ДНБ-д эзлэх хувь	-9.5	-8.0	0.1
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	1,623.0	1,928.5	1,680.4
	ДНБ-д эзлэх хувь	5.9	6.3	5.2
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /их наяд төгрөг/	22.2	24.3	19.1
	ДНБ-д эзлэх хувь	80.0	80.0	59.4
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	499.6	646.0	361.8
	ДНБ-д эзлэх хувь	1.8	2.1	1.1

2.3.8.Монгол Улсын 2019 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар

2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн өөрчлөлтийн тухайд

2018 оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн өсөлт сэргэж, нүүрсний экспорт эрчимтэй нэмэгдэж, голлох ашигт малтмалуудын үнэ харьцангуй өндөр түвшинд байгаа болон уул уурхай, түүнийг дагасан эдийн засгийн бусад салбарын өсөлтөөс үүдэн бизнесийн орчин харьцангуй идэвхжиж, аж ахуйн нэгжүүдийн борлуулалт, ашигт ажиллагаа нэмэгдсэнтэй холбоотойгоор тайлант онд төвлөрүүлэхээр тооцсон төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс давах шинж ажиглагдсан. Улмаар 2019 оны Монгол Улсын нэгдсэн төсвийг батлахтай холбогдуулан ТХМТТХ-д тусгасан зарим макро эдийн засгийн үзүүлэлтэд өөрчлөлт оруулах шаардлага үүсжээ.

Тус өөрчлөлтөөр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нэгдсэн төвийн тэнцвэржүүлсэн зарлагын дээд хэмжээг нэмэгдүүлж ДНБ-ий өсөлтийг 8.0 хэвээр байхаар тооцож баталсан бол бодит гүйцэтгэлээр төсвийн орлого 1,229 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 10,905.5 тэрбум болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 1,182.0 тэрбум төгрөгөөр буурч -756.2 тэрбум төгрөг гарсан байна.

Хүснэгт 11.2019 оны ТХМТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2018.05.25 /баталсан/	2018.11.02 /өөрчлөлт/	Гүйцэтгэл 2019
1	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/	8.0	8.0	5.6
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.0	8.0	5.2
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	8,888.0	9,676.5	10,905.5
	ДНБ-д эзлэх хувь	25.6	27.4	29.6

4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	10,993.8	11,589.8	11,661.7
	ДНБ-д эзлэх хувь	31.7	32.8	31.6
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	1,342.3	1,938.2	2,438.8
	ДНБ-д эзлэх хувь	3.9	5.5	6.6
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-2,105.8	-1,913.3	-756.2
	ДНБ-д эзлэх хувь	-6.1	-5.4	-2.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	2,890.1	3,251.8	3,016.7
	ДНБ-д эзлэх хувь	8.3	9.2	8.2
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /их наяд төгрөг/	19.2	19.6	20.5
	ДНБ-д эзлэх хувь	55.3	55.3	55.5
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	677.9	694.5	668.3
	ДНБ-д эзлэх хувь	2.0	2.0	1.8

2.3.9. Монгол Улсын 2020 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар

2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн эхний өөрчлөлтийн тухайд

2019 оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн өсөлт сэргэж 7.3 хувьд хүрсэн, зэсээс бусад голлох ашигт малтмалын үнэ тогтвортой байж, уул уурхай, түүнийг дагасан эдийн засгийн бусад салбарын өсөлт, аж ахуйн нэгжүүдийн борлуулалт, ашигт ажиллагаа нэмэгдсэн болон татвар, гаалийн шинэчлэл, газрын төлбөрийг бүрэн хураах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг сайжруулсны дүнд 2020 онд төвлөрүүлэхээр тооцоолсон төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс давах төлөвтэй байх тул ТХМТТХ-д өөрчлөлт оруулан төсвийн орлого, зарлагыг нэмэгдүүлсэн.

2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 2 дахь өөрчлөлтөөр төсвийн зарим тусгай шаардлагын түдгэлзүүлсэн тухай

Ковид-19 дэлхий нийтийг хамарч, улс орнуудын нийгэм, эдийн засагт урьдчилан тооцоогүй их хэмжээний хохирол учруулсан. Үндэсний статистикийн хорооноос Монгол Улсын ДНБ (оны үнээр тооцсон) 2020 оны эхний улиралд 7.4 их наяд төгрөгт хүрч эдийн засгийн өсөлт өмнөх оны мөн үеэс 10.7 хувиар буурсан бол хоёрдугаар улиралд 7.8 их наяд хүрч 9.7 хувиар буурсныг зарласан.

Ковид-19-ийн нөлөөгөөр уул уурхайн голлох бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээлийн үнэ болон эрэлт буурснаар 2020 онд Монгол Улсын экспортын хэмжээ буурч, төсвийн орлого саарснаар эдийн засгийн өсөлт удааширч эхэлсэн.

Дээр дурдсан нөхцөл байдал нь ТТБТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт нь өмнөх жилтэй харьцуулахад 0 эсхүл түүнээс бага бол”, 8.1.2 “гамшгийн аюулын хор уршиг, онцгой нөхцөлийн үр дагаврыг арилгахад төсвөөс нэмж шаардагдах санхүүжилтийн хэмжээ нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувь ба түүнээс дээш хэмжээнд хүрэхээр бол” гэж заасан. Хуульд заасан нөхцөл байдалд хүрсэн нь төсвийн зарим тусгай шаардлагын үйлчилгээг түр түдгэлзүүлэх үндэслэл болсон.

Хүснэгт 12.2020 оны ТХМТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2019.05.30 /баталсан/	2019.11.13 /өөрчлөлт/	2020.08.28 /өөрчлөлт/	Гүйцэтгэл 2020
1	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/	6.0	6.0	-1.0	-4.6
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.0	8.0	3.8	2.3
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	11,122.6	11,797.8	9,730.9	9,463.8
	ДНБ-д эзлэх хувь	27.3	29.0	25.2	25.6
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	13,197.4	13,872.6	14,577.5	13,904.3
	ДНБ-д эзлэх хувь	32.0	34.1	37.7	37.6
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	1,608.3	2,283.5	704.9	2,242.6
	ДНБ-д эзлэх хувь	4.0	5.6	1.8	6.1
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-2,074.7	-2,074.7	-4,846.6	-4,440.4
	ДНБ-д эзлэх хувь	-5.1	-5.1	-12.5	-12.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	3,491.4	3,806.1	3,408.0	3,034.2
	ДНБ-д эзлэх хувь	8.6	9.4	8.8	8.2
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /их наяд төгрөг/	22.1	22.1	24.1	23.0
	ДНБ-д эзлэх хувь	54.3	54.3	62.2	62.2
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	750.2	756.6	1,650.2	1,534.3
	ДНБ-д эзлэх хувь	1.8	1.9	4.3	4.1

2.3.10. Монгол Улсын 2021 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар

2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн эхний өөрчлөлтийн тухайд

2020 онд дэлхий нийтийг хамраад буй Ковид-19 гарснаар эдийн засгийн өсөлт 2020 оны эхний хагас жилийн байдлаар 9.7 хувиар агшсан байна. Цар тахлын тархалт сүүлийн саруудад эрчимтэй нэмэгдэж Ковид-19-ийн хоёр дахь давлагаа эхэлснийг олон улсын байгууллагууд анхааруулсан. Иймд Монгол Улсын Засгийн газраас 2020 онд хэрэгжүүлсэн эдийн засгийн идэвхжүүлэх, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийг дэмжих бодлогын зарим арга хэмжээнүүдийг 2021 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа нь ТХМТТХ-д өөрчлөлт оруулах шаардлагыг үүсгэсэн.

Тус өөрчлөлтөөр нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээг 100 орчим тэрбум төгрөгөөр бууруулж, Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээг 500 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж баталжээ.

2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 2 дахь өөрчлөлтийн тухайд

Дэлхий даяар эрчимтэй тархсан Ковид-19 нь Монгол Улс төдийгүй дэлхийн бусад улсуудын нийгэм, эдийн засагт урьдчилан таамаглаагүй сөрөг нөлөөллийг үзүүлсэн. Уг нөхцөл байдлын улмаас Монгол Улсын 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах үед тооцсон эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ, хэмжээ, төсвийн

хүрээний мэдэгдэлд тусгагдсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, ялангуяа ДНБ-ий хэмжээ буурахаар байгаа нь ТХМТТХ-д өөрчлөлт оруулах шаардлага үүсгэсэн.

Мөн цар тахлын эсрэг цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд шаардагдах төсвийн зардлыг төсөвт тусгаснаар төсвийн алдагдал нэмэгдэхээр байгаа нь өөрчлөлтийн төслийг боловсруулах практик үндэслэл болсон.

Тус өөрчлөлтөөр нэгдсэн төсвийн зарлагын дээд хэмжээг 1,796.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 3,691.8 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар баталсан. Бодит гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн тэнцэл 2,919.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарахад төсвийн орлого 655 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 13. 2021 оны ТХМТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл:

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2020.08.28 /баталсан/	2020.11.13 /өөрчлөлт/	2021.07.07 /өөрчлөлт/	Гүйцэтгэл 2021
1	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/	7.2	7.2	6.5	1.6
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	7.0	7.0	7.2	13.4
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	11,797.8	11,797.8	12,056.4	12,711.4
	ДНБ-д эзлэх хувь	27.9	27.9	28.6	34.4
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	13,951.6	13,951.6	15,748.3	15,630.4
	ДНБ-д эзлэх хувь	33.0	33.0	37.4	42.3
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	-625.9	-625.9	1,844.0	1,693.9
	ДНБ-д эзлэх хувь	-1.5	-1.5	4.4	4.6
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-2,153.7	-2,153.7	-3,691.8	-2,919.0
	ДНБ-д эзлэх хувь	-5.1	-5.1	-8.8	-7.9
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	3,647.2	3,540.7	3,363.5	2,982.2
	ДНБ-д эзлэх хувь	8.6	8.4	8.0	8.1
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /их наяд төгрөг/	26.1	26.1	25.8	21.8
	ДНБ-д эзлэх хувь	61.9	61.9	61.3	59.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	824.1	1,363.8	2,994.7	2,851.1
	ДНБ-д эзлэх хувь	2.0	3.2	7.1	7.7

2.3.11. Монгол Улсын 2022 оны ТХМТТХ-ийн өөрчлөлтийн талаар

2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн өөрчлөлтийн тухай

2021 оны эхний хагас жилд эдийн засаг 6.3 хувиар өсөж, 2021 оны жилийн эцэст 6.5 хувь, 2022 онд 5.0 хувьд хүрч цаашид өсөлт тогтворжино гэж төсөөлсөн.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийг Ковид-19-ийн дараах улс орны эдийн засгийг эрчимтэй сэргээх зорилтыг хангахад чиглүүлж, хөдөлмөр эрхлэлт, бүтээмжийг нэмэгдүүлэх, улмаар эдийн засгийг төрөлжүүлж, дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг хэрэгжүүлэх шаардлага үүсэж ТХМТТХ-д өөрчлөлт оруулсан.

Тус өөрчлөлтөөр ДНБ-ий өсөлтийн 4.6-5.0 болгож, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 2,565.3 тэрбум төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 3,306.8 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын өрийн нийт хэмжээг 3.7 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж баталсан ч 3 сар хүрэхгүй хугацааны дараа дахин өөрчлөлт оруулж тус хууль хүчингүй болжээ.

2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн өөрчлөлтийн тухай

Цар тахлын үеийн эрсдэлийг даван туулахын тулд 2020-2021 онд Засгийн газраас иргэдээ вакцинжуулах, иргэдийн орлого, ажлын байрыг хамгаалах, аж ахуйн нэгж, бизнесийг дэмжихэд чиглэсэн нийт 6.9 их наяд төгрөгийн цогц арга хэмжээг төсвөөс үе шаттай хэрэгжүүлсэн.

Үүний үр дүнд 2021 оны 3 дугаар улиралд эдийн засаг 3.6 хувиар өсөж, 2021 оны жилийн эцэст экспортын орлого түүхэндээ анх удаа 9.2 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 2.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан. Монгол Улсын 2021 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 102.7 хувийн биелэлттэй, үүнээс нийгмийн даатгалын сангийн орлого төлөвлөсөн хэмжээнээс 322.3 тэрбум төгрөгөөр давж биелжээ. Улмаар дотоодын нийт бүтээгдэхүүний 8.8 хувьтай тэнцүү байхаар батлагдсан төсвийн тэнцвэржүүлсэн алдагдлын хэмжээ 1.9 пунктээр буурч 6.9 хувьд хүрсэн эерэг үзүүлэлттэй гарчээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэхэд чиглэсэн тодорхой шийдлийг дотоод нөөц бололцоогоо дайчлан яаралтай боловсруулж, үе шаттай авч хэрэгжүүлэн ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосны дагуу Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтыг үндэслэн 2022 оны улсын төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсөвт тодотгол хийх замаар Нийгмийн даатгалын сангийн 2021 оны давсан орлогын эх үүсвэрийг ашиглан ахмадуудын тэтгэврийг үе шаттай нэмэгдүүлэхээр тооцсон.

Энэхүү төсвийн зохицуулалтыг ТТБТХ-д нийцүүлэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан нэгдсэн төсвийн орлого, зарлага ба алдагдлын нийт хэмжээг өөрчлөхгүйгээр, төсвийн тусгай шаардлагыг баримтлан нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээг бууруулан төсвийн тогтвортой байдлыг хангах замаар хэрэгжүүлэхээр болсон.

2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн өөрчлөлтийн шалтгаан³

2022 оны 02 дугаар сард үүссэн Оросын Холбооны Улс болон Украйны дайны нөхцөл байдал, дэлхийн геополитик, эдийн засгийн нөхцөл байдалд урьдчилан тооцоолох боломжгүй хүндрэл үүсгэсэн. Тус зэвсэгт мөргөлдөөний улмаас дэлхийн зах зээлд түүхий эдийн үнэ, ханшийн савлагаа ихсэж, нийлүүлэлтийн тасалдал үүсэх эрсдэл үүссэнээр импортлогч орнуудын шатахуун, эрчим хүч болон хүнсний бүтээгдэхүүний үнэд нөлөөлж эхэлсэн. Дэлхийн зах зээлд үйлдвэрийн орц болох шатахуун, байгалийн хий, хүнс, бараа материалын үнийн хэлбэлзэл өндөр байгаа нь улс орнуудад инфляцын дарамтыг нэмэгдүүлэх, улмаар эдийн засгийн өсөлт анхны төсөөллөөс удаашрах төлөвийг бий болгосон.

Түүнчлэн, БНХАУ-д Ковид-19 дахин эрчимжсэнээр тус улсаас хилийн хоригуудаа чангаруулах, халдварыг тогтоох “тэг-Ковид” стратегийг хэрэгжүүлж эхэлсэн.

³ ТХМТТХ-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хувийн хэргээс

Дээр дурдсан нөхцөл байдлуудаас шалтгаалан Монгол Улсын 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, ялангуяа ДНБ-ий бодит хэмжээ буурах, инфляцын түвшин нэмэгдэхээр байгаа нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн хэмжээг өөрчлөх зайлшгүй шаардлагатай гэж үзсэн.

Тус өөрчлөлтөөр ДНБ-ий өсөлтийг 2.6 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 15,526.4 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 17,913.5 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2,387.1 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар тооцоолж баталсан. Бодит гүйцэтгэлээр төсвийн орлого 17,126.9 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 1,600.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, ДНБ-ий өсөлт 4.8 хувьтай гарсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 1,032.7 тэрбум төгрөг болж 1,354.4 тэрбум төгрөгөөр буурахад нөлөөлжээ.

Хүснэгт 14.2022 оны ТХМТТХ, өөрчлөлт, гүйцэтгэл⁴:

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2021.05.13 /баталсан/	2021.11.12 /өөрчлөлт/	2022.01.31 /өөрчлөлт/	2022.04.29 /өөрчлөлт/	Гүйцэтгэл 2022
1	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/	4.6	5.0	5.0	2.6	4.8
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	6.0	6.7	6.7	11.5	13.2
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	13,206.4	15,771.7	15,771.7	15,526.4	17,126.9
	ДНБ-д эзлэх хувь	28.9	33.7	33.7	33.3	32.4
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	14,852.0	18,158.8	18,158.8	17,913.5	18,159.6
	ДНБ-д эзлэх хувь	32.5	38.8	38.8	38.4	34.3
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	900.4	2,410.5	2,410.5	2,165.2	2,579.7
	ДНБ-д эзлэх хувь	2.0	5.2	5.2	4.6	4.9
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,645.6	-2,387.1	-2,387.1	-2,387.1	-1,032.7
	ДНБ-д эзлэх хувь	-3.6	-5.1	-5.1	-5.1	-2.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	3,768.9	5,197.1	4,809.6	4,296.3	3,803.4
	ДНБ-д эзлэх хувь	8.2	11.1	10.3	9.2	7.2
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /их наяд төгрөг/	27.1	31.4	31.4	28.3	26.9
	ДНБ-д эзлэх хувь	59.2	67.2	67.2	60.7	50.8
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	851.3	490.4	490.4	490.4	511.6
	ДНБ-д эзлэх хувь	1.9	1.0	1.0	1.1	1.0

⁴ Эх сурвалж: Батлагдсан хуулиуд болон Сангийн яамнаас ирүүлсэн төсвийн гүйцэтгэлээс

2.3.12. Практикт нийцэж байгаа эсэх шалгуур үзүүлэлтийг дүгнэвэл

Улсын нэгдсэн төсвийн төсөл хэлэлцэж батлах үеийн эдийн засгийн нөхцөл байдал ТХМТТХ-ийг баталсан үеэс эрс өөрчлөгдсөн. Иймд цаг үед нийцүүлсэн төсвийн төсөл боловсруулсан тул түүнд нийцүүлэн ТХМТТХ-д өөрчлөлт оруулах шаардлагатай үүсэж, 2012-2022 онд жил бүрийн 5 сард баталсан ТХМТТХ-д 6 сар хүрэхгүй хугацаанд эхний өөрчлөлтийг оруулсан.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-т “Улсын Их Хурал Стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэж, батлах” гэж заасныг үндэслэн жил бүрийн 5 сард баталсан ТХМТТХ нэг ч удаа хэрэгжээгүй, хагас жилийн хугацаанд өөрчлөлт оруулдаг нь тус хууль практикт нийцэх шалгуур үзүүлэлтийг хангаагүйг илтгэж байна.

Хэдийгээр МУНТХ-д нийцүүлж ТХМТТХ-д өөрчлөлт оруулсан ч гүйцэтгэлээр хуульд заасан нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хязгаарыг давуулсан тохиолдлууд гарсан нь тус хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харууллаа.

3. ДҮГНЭЛТ

Үнэлгээний баг 2012-оос 2022 оныг 3 цаг үед хувааж, тус бүрийн эдийн засгийн нөхцөл байдалд, тухайн хуулийн хэрэгжилт хэрхэн хангагдсан, хууль практикт нийцсэн эсэх талаарх үнэлэлт, дүгнэлт хийлээ.

2012-2015 он: Төсвийн төлөвлөлтийг хэт өөдрөгөөр төлөвлөж байсан үе.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2011 онд тухайн үеийн хамгийн дээд цэгтээ буюу 4.7 тэрбум ам.долларт хүрснээс хойш тасралтгүй буурч 2015 оны эхний улирлын байдлаар 644 сая ам.долларт хүрсэн байна. Гадаадын хөрөнгө оруулалтын 80⁵ хувь нь жилээс жилд уул уурхайн салбарт төвлөрдөг бөгөөд дэлхийн зах зээл дэх нүүрс, зэсийн үнэ унасан нь хөрөнгө оруулагчдын эргэлзээг төрүүлсэн байна. Уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татагч гол төсөл болох “Оюутолгой” төсөл нь хөрөнгө оруулагч тал болон Монголын засгийн газрын маргаантай асуудлаас болж 2013 оны 08 дугаар сараас эхлэн түр зогссон төдийгүй 2016 он сонгуулийн жил болж байгаатай холбоотойгоор гадаадын хөрөнгө оруулагчид байдлыг харзнах, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхгүйгээр түр хүлээх нөхцөл үүсэж, шууд хөрөнгө оруулалтын дотогшлох урсгал эрс буурсан нь Эдийн засгийн өсөлт саарах шалтгаан болсон байна.

Эдийн засаг буурч байх энэхүү хугацаанд тухайн үеийн Засгийн газар макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд /эдийн засгийн бодит өсөлт болон инфляц/-ийг өөдрөгөөр төлөвлөж, төсвийн төлөвлөлтийг хийж байсан. Үүнээс гадна олон төсөвтэй байсан бөгөөд “Чингис бонд” болон Монголбанкнаас үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар импортын хэрэглээг дэмжсэн бодлого хэрэгжүүлж байсан нь гадаад валюттай харьцах төгрөгийн ханш огцом сулрах, төсвийн зардал болон алдагдлыг нэмэгдүүлэх үндэс болсон. Тухайлбал 2012-2015 онд эдийн засгийн өсөлт болон инфляцыг өөдрөгөөр төлөвлөж, төсвийн орлого болон зардлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ ТТБТХ-д анх удаа өөрчлөлт оруулж, төсвийн алдагдал болон Засгийн газрын өртэй холбоотой төсвийн тусгай шаардлага, шалгуур үзүүлэлтүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулж, нөхцөлийг сулруулжээ.

Дэлхийн банкнаас улирал тутам гаргадаг Монгол Улсын эдийн засгийн тоймд хэт өөдрөг төсөөлөх нь эрсдэлтэй, цаашид эдийн засгийн өсөлт саарах төлөвтэй байгааг удаа дараа анхааруулсан байсан ч Монгол Улсын засгийн газар эдийн засгийн хамгийн

⁵ 2015 оны Хөрөнгө оруулалтын орчны тухай мэдэгдэл, Эдийн засаг худалдааны хэлтэс

чухал, суурь үзүүлэлт болсон ДНБ-ий өсөлтийг хэт өөдрөгөөр тооцож, төсвийг төслийг боловсруулж байсан нь ирэх онуудын төсвийн зарлага, төсвийн тэнцлийн алдагдал, засгийн газрын өрийн хэмжээг ихэсгэх томоохон хүчин зүйл болсон байна.

2016-2019 он: ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдсан үе

2016 онд олон төсвүүдийг нэгтгэх, Хөгжлийн банкны зарцуулалт, концесс, векселийн бодлогод өөрчлөлт оруулах замаар төсвийн үр ашиг, төсвийн сахилга батыг сайжруулах бодлого баримталж эхэлсэн бөгөөд 2016 оны III улирлаас эхлэн дэлхийн зах зээл дээрх уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн нь эдийн засаг сэргэх таатай нөхцөл бүрдсэн

2017 оны 5 дугаар сараас эхлэн 3 жилийн хугацаатай ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдсанаар макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг оновчтой төлөвлөх, зарим төрлийн урсгал зардлуудыг царцаах, төсвийн үр ашиггүй зардлуудыг танах, өндөр хүүтэй дотоодын бондын арилжааг зогсоож, зээлийн үйлчилгээний зардлыг багасгах замаар урсгал зардлыг бууруулах зэрэг бодлогууд баримталсны үр дүнд 2018 онд төсөв ашигтай гарсан.

ОУВС-ийн хөтөлбөрт хамрагдсанаар эдийн засгийн үзүүлэлтүүдийг харьцангуй бодитой тооцож эхэлсэн ч МУНТТХ батлах үед ТХМТТХ-д заавал өөрчлөлт оруулсан хэвээр байсан нь тус хуулийг эхний хагас жилийн гүйцэтгэл гараагүй буюу тухайн жилийн 05 дугаар сард баталдаг цаг хугацаа нь практикт нийцэхгүй байна. Иймд ТХМТТХ-ийг жил бүрийн 06 дугаар сарын 01-ний дотор баталдаг байдлын хугацаанд өөрчлөлт оруулах шаардлагатайг илтгэж байна.

2019-2022 он: Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үе

2019-2022 онд дэлхий дахиныг хамарсан Ковид-19-тэй Монгол Улс тэмцэж, төсвийн зардлыг ихээхэн хэмжээгээр нэмэгдүүлсэн нь Монгол Улсын төсвийн дунд хугацааны бодлого төлөвлөлтөд сөргөөр нөлөөлсөн.

Энэ хугацаанд Ковидын тухай хуулийг шинээр баталсан, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагуудад өөрчлөлт оруулсан зэрэг нь төсвийн зарлагыг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлжээ.

Ковид-19-ийн нөлөөллийг эдийн засагт богино хугацаанд “V хэлбэр”-ийн огцом уналт, сэргэлтийн байдлаар тооцоолж байсан бол эсрэгээрээ урт хугацаанд сунжирч, эдийн засаг үргэлжлэн унасан нь дунд хугацааны төсвийн бодлого төлөвлөлтөд сөргөөр нөлөөлжээ.

ТХМТТХ-ийг тухайн оны 5 дугаар сард батлахдаа дараа жилийн ДНБ-ий өсөлтийг урьдчилан тооцоолж, түүнд тулгуурлан төсвийн зарлага, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, Засгийн газрын өрийн хэмжээг тооцоолж баталдаг байдал нь 2012-2022 оны хугацаанд аль ч цаг үед практикт нийцэхгүй байгааг харуулж байна. Эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарч МУНТТХ-тай зэрэгцэн ТХМТТХ-д өөрчлөлт оруулсан нь тус хуулийн дагаж мөрдөх бус бэлгэдлийн чанартай байдлаар хэрэгжүүлсээр ирснийг илэрхийлж байна.

4.3ӨВЛӨМЖ

Төсвийн төлөвлөлтийн хувьд:

- Төсвийн дунд хугацааны бодлого төлөвлөлт алдагдаж, жил бүрийн 05 дугаар сард ТХМТТХ батлагдаж хагас жилийн дараа буюу 11 дүгээр сард төсвийн тухай хуулийн төсөлд нийцүүлэн уг батлагдсан хуульд өөрчлөлт оруулдаг хэвшмэл ойлголтыг халах;
- Тухайн жилийн төсвийн нийт зарлагын өсөлтийг ДНБ-ий бодит өсөлт болон төсвийн орлогын өсөлтөөс илүү хэмжээгээр өсгөдөг байдлыг зогсоох, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн зарлагын дээд хэмжээг орлогын өсөлтөөс бага байлгахаар хуульчлах;
- ДНБ-ий бодит өсөлтийг биелэгдэхүйц доод хэмжээгээр төлөвлөх, бодит өсөлт өндөр гарсан тохиолдолд хөгжлийн асуудлуудад зарцуулах, ирээдүйд зориулан хуримтлал үүсгэх;
- Цаашид тухайн оны эхний хагас жилийн эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн гүйцэтгэлийн үр дүн гарсан үед дараа жилийн макро эдийн засгийн төлөв байдлыг тооцоолж ТХМТТХ-ийн төслийг боловсруулдаг болох;
- Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг дараа жилийн төсөөллийн ДНБ-ий хувиар хязгаарладаг бус, эхний хагас жилийн гүйцэтгэлд үндэслэж тооцоолсон тухайн жилийн ДНБ-ий төсөөлөлд үндэслэж хязгаарлалт тогтоодог болох;
(Тухайлбал; 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг батлахдаа нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлд үндэслэж тооцсон 2023 оны ДНБ-ий тодорхой хувиас хэтрүүлэхгүй байх заалтыг хуульчилж, хаврын ээлжит чуулганы хугацаанд буюу 7 сард баталдаг болох)
- Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг богино хугацаанд, баталгаатай, үр дүнгээ өгөх үйлдвэрлэлийн салбаруудад зарцуулж, ажлын байр шинээр бий болгох, татварын бааз суурийг өргөжүүлж, өрийн эрсдэлийг бууруулах;
- Төсвийн хөрөнгийн зардлыг төлөвлөсөн хэмжээнд хүргэхийн тулд урсгал зардлыг ихээр бууруулж чадах бүтцийн томоохон өөрчлөлт хийх;
- Хууль боловсруулагч ТХМТТХ-д тусгасан макро эдийн засгийн үзүүлэлтийг тооцоолсон арга аргачлалын тухай үндэслэлтэйгээр тайлбарлаж, нэгэнт батлагдсан хуульд өөрчлөлт оруулах бус тухайн хуульд нийцүүлэн Улсын нэгдсэн төсвийн төслийн боловсруулдаг болох;

Төсөв, эдийн засгийн бодлогын хувьд:

- Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл нэмэгдсэн, экспортын төрөлжилт суларсан, импортын хамаарал ихтэй болсон, төгрөгийн ханш тогтмол суларч байгаа, эдийн засгийн бүтэц сул байгаа зэргийг анхаарч эдийн засгийн бодлогод шинэтгэл хийж, эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах, гадаад нөлөөллийг бууруулах шаардлагатай;
- Уул уурхайн бус экспорт болон, импортыг орлох бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжих;

- Монгол Улсын ДНБ-ий бүтцийг нийтэд нь харахад, хэрэглээ давамгайлсан, эдийн засгийн бүтцийн хувьд салбар хоорондын тэнцвэр алдагдсан, суурь судалгаануудыг хийж, онол, практикийн үндэслэлтэй бодлого, шийдвэр гаргаагүй зэрэг нийтлэг дүр төрх харагдаж байна. Иймд судалгаанд суурилсан төсвийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж ТТБтХ-ийг чанд мөрдүүлэх зэрэг болно.

ТХМТТХ-д заасан макро эдийн засгийн үзүүлэлтүүд бодит гүйцэтгэлээр
батлагдсан түвшинд хүрсэн эсэх

ТХМТТХ	1.ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/										
	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Анх баталсан	-	-	-	-	-	✓	✓	-	-	-	✓
Сүүлийн өөрчлөлт	-	-	-	-	✓	✓	✓	-	-	-	✓
2.Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин ⁶											
Анх баталсан	-	-	-	-	-	✓	✓	-	-	-	-
Сүүлийн өөрчлөлт	-	-	✓	-	-	✓	✓	-	✓	-	✓
3.Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/											
Анх баталсан	✓	-	-	-	-	✓	✓	✓	-	✓	✓
Сүүлийн өөрчлөлт	-	-	-	-	✓	✓	✓	✓	-	✓	✓
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээний ДНБ-д эзлэх хувь											
Анх баталсан	✓	-	-	-	-	✓	✓	✓	-	✓	✓
Сүүлийн өөрчлөлт	-	-	-	-	✓	✓	✓	✓	✓	✓	✓
4.Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/											
Анх баталсан	-	✓	✓	✓	-	-	✓	-	-	-	-
Сүүлийн өөрчлөлт	✓	✓	✓	✓	✓	✓	✓	-	✓	✓	-
Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээний ДНБ-д эзлэх хувь											
Анх баталсан	-	✓	✓	✓	-	-	✓	✓	-	-	-
Сүүлийн өөрчлөлт	-	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	-	✓
5.Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/											
Анх баталсан	-	-	-	✓	✓	-	✓	-	-	-	-
Сүүлийн өөрчлөлт	-	-	-	✓	✓	✓	✓	-	-	✓	-
Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээний ДНБ-д эзлэх хувь											
Анх баталсан	✓	✓	-	✓	-	-	✓	-	-	-	-
Сүүлийн өөрчлөлт	✓	✓	-	✓	✓	✓	✓	-	-	-	-
6.Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/											
Анх баталсан	-	✓	-	-	-	✓	✓	✓	-	-	✓
Сүүлийн өөрчлөлт	-	✓	-	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь											
Анх баталсан	-	✓	-	-	-	✓	✓	✓	-	-	✓
Сүүлийн өөрчлөлт	-	✓	-	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓

⁶ Хуульд заасан хэмжээнээс ± 2 пункт хувийг хэвийн хэмжээнд гэж үзэж ✓ тэмдэгээр тэмдэглэв.

7.Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/											
Анх баталсан	-	✓	✓	✓	-	-	-	-	✓	✓	-
Сүүлийн өөрчлөлт	✓	✓	✓	✓	-	✓	✓	✓	✓	✓	✓
Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээний ДНБ эзлэх хувь											
Анх баталсан	-	✓	✓	✓	-	-	✓	✓	✓	✓	✓
Сүүлийн өөрчлөлт	✓	✓	✓	✓	-	✓	✓	✓	✓	-	✓
8.Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /их наяд төгрөг/											
Анх баталсан			-	-	-	✓	✓	-	-	✓	✓
Сүүлийн өөрчлөлт			-	✓	✓	✓	✓	-	✓	✓	✓
Засгийн газрын өрийн нийт хэмжээний ДНБ-д эзлэх хувь											
Анх баталсан			-	-	-	✓	✓	-	-	✓	✓
Сүүлийн өөрчлөлт			-	✓	✓	✓	✓	-	✓	✓	✓
9.Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/											
Анх баталсан		✓	✓	✓	✓	✓	✓	✓	-	-	✓
Сүүлийн өөрчлөлт		✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	-
Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээний ДНБ-д эзлэх хувь											
Анх баталсан		✓	✓	✓	✓	✓	✓	✓	-	-	✓
Сүүлийн өөрчлөлт		✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓

(-) Төсвийн орлого зорилтот хэмжээнд хүрээгүй эсхүл төсвийн зарлага зорилтот хэмжээнээс давсан, үр дүнд хүрээгүй жилүүд

(✓) Төсвийн орлого, зорилтот хэмжээнээс давсан, төсвийн зарлага зорилтот хэмжээнээс хэтрээгүй, хуульд заасан хэмжээнд байгаа жилүүд